



Арьс харшлын багц шинжилгээний бэлтгэл

Энэ багцыг сонгосноор дараах зөвлөгөөнүүдийг өгнө.

- Арьсны хэв шинж тодорхойлох
- Арьс арчилгаа, гоо сайхны зөвлөгөө өгөх
- Үс, хумс, хөлсний болон тосны булчирхайг дүгнэх
- Арьсны эвэр, үү, ургацаг авах зөвлөгөө өгөх
- Арьсны бүх төрлийн өвчний оношлогоо, эмчилгээ зөвлөх
- Харшил, харшил төст эмгэгүүдийн оношлогоо, эмчилгээ хийх
- Ургамлын харшлын үед өвөрмөц дархлаа тогтоох урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулж, хянах

Цусны шинжилгээний бэлтгэл:

- Өлөн байх /8–12 цагийн турш хоол идээгүй болон газтай болон чихэрлэг ундаа, зөгийн бал болон чихэртэй цай уугаагүй байх/
- 24 цаг өмнөөс архи согтууруулах ундаа хэрэглээгүй, өөх тос ихтэй хоол идээгүй, биеийн хүчний дасгал болон хэт ачаалал аваагүй байвал илүү тохиромжтой.
- Цус өгөхийн өмнө эхо, дуран, рентген зэрэг багажийн шинжилгээнд ороогүй, судсаар тодосгогч бодис хэрэглээгүй байна.

Мазокын шинжилгээ:

Эрэгтэй

- Давсганд шээстэй байвал илүү тохиромжтой
- Өмнөх өдөр нь бэлгийн харьцаанд ороогүй байх

Эмэгтэй

- Давсганд шээсгүй байх
- Сарын тэмдэг ирээгүй байх
- Өмнөх өдөр нь бэлгийн харьцаанд ороогүй байх
- Дотуур угаалга хийгээгүй байх

Харшлын сорил:

- 3 өдөр харшлын эм уугаагүй байх
- Жирэмсэн болон хөхүүл биш байх

Жич: Дээрх шинжилгээний хариу гарсны дараа нэмэлт шинжилгээ шаардлагатай бол төлбөр тусдаа тооцогдоно.
Бусад нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлага гарвал 7 хоног дотор үзлэгийн төлбөрөөс 50%-ийн хөнгөлөлт эдлүүлнэ.